ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: ӨВА-2022/30-13-ШТА-ГА**

Арвайхээр хот
2022 он

**Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал**
Утас: 70323253, цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
**Аудитын менежер Д.Гансүх,**
Утас: 70323833, цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn
**Ахлах аудитор: П.Хорлоосүрэн,**
Утас: 70323108, цахим хаяг: Khorloosurenp@audit.gov.mn
**Аудитор: Э.Энхбаяр,**
Утас: 70323108, цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
**Аудитор: Ө.Ринчинмядаг,**
Утас: 70323108, цахим хаяг: RinchinmyadagU@audit.gov.mn

**Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn**

***АГУУЛГА***

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ ....3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ ....4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ....4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ....4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ ....5
1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БАЙНА....8
1.1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарийн дагуу санхүүжилтээ олгосон болович малын тоо толгойн албан татварыг дутуу төвлөрүүлсэн байна. ....8
1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэр бүрдүүлэлт аймагт хамааралгүй болно ....8
1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль, журмыг баримталж хуваарилан олгосон байна ....8
1.1.3. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгожээ....8
1.1.4. Сумууд ОНХС-д хуулиар олгогдох эх үүсвэр болох малын тоо толгойн албан татварын орлогыг орон нутгийн хөгжлийн санд бүрэн төвлөрүүлээгүй байна....9
1.2. Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог бүрэн хангаагүй, орон нутгийн хөгжлийн бодлоготой бүрэн уялдуулаагүй байна ....10
1.2.1. Төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг тэгш хүртээмжтэй аваагүй, ач холбогдол, саналын тоогоор эрэмбэлэх ажил хангалтгүй байна ....10
1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй тэдийлэн уялдуулахгүй байна....15
1.2.3. Аймаг, сумын ОНХС-аас Засаг даргын чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг тусгасан байна ....15
1.2.4. Аймаг, сумдын түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг холбогдох хууль журмын дагуу төлөвлөсөн байна ....17
2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ИХЭНХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ЗАРИМ ХӨРӨНГИЙН ЧАНАР, АШИГЛАЛТ,ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА. ....17
2.1 Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан боловч зарим ажил зориулалт бусаар зарцуулагдсан байна ..17
2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна....17
2.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ихэнх ажлууд хууль, журмын дагуу явагдсан ч зарим хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна ....18
2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ихэнх төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй хийгдсэн боловч зарим ажлын чанар хангалтгүй байна ....18
2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй байна ....18

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ихэнх төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд бодит үр дүнгээ үзүүлсэн боловч зарим ажлууд чанар муутай хийгдсэн байна ....20
2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна ....24
2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна ....24
2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй, аймаг, сумдын ИТХ, иргэдийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна ....25
3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ БҮРЭН ХЯНАЛТ ТАВЬЖ, ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА ....27
3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хийсэн хяналт хангалтгүй байна....27
3.1.1. Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд хийсэн хяналт хангалтгүй байна....27
3.1.2 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна....28
3.1.3. Төрийн аудитын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил бүрэн биелэгдэж, дотоод аудит, хяналт шалгалт 2021 онд хийгдээгүй байна....30
3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу хүргүүлсэн боловч тайлагналт хангалтгүй байна ....31
3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг тайлагнасан боловч хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна ....31
3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэж тайлагнасан байна. ....32
3.2.3. Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэдэд ил тод нээлттэй мэдээлэх ажил хангалтгүй байна. ....32
3.2.4. ОНХС-гийн хөрөнгийн санхүүжилтийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх ажил хангалтгүй байна. ....34
САНАЛ-НЭГДСЭН ТАЙЛАНД ....35
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ....36
ДҮГНЭЛТ ....37
ЗӨВЛӨМЖ....39
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ....41

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ***АДБОУБ*** | Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага |
| ***АДБОУС*** | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| ***БИНХ*** | Багийн иргэдийн Нийтийн хурал |
| ***ГХБХБГ*** | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар |
| ***ЖГҮ*** | Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ |
| ***ЗДТГ*** | Засаг даргын тамгын газар |
| ***ИНХ*** | Иргэдийн нийтийн хурал |
| ***ИТХ*** | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ***МХГ*** | Мэргэжлийн хяналтын газар |
| ***ОНӨААТҮГ*** | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ***ОНХНС*** | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан |
| ***ОНХС*** | Орон нутгийн хөгжлийн сан |
| ***СӨББ*** | Сургуулийн өмнөх боловсролын байгууллага |
| ***ТЭЗҮ*** | Техник, эдийн засгийн үндэслэл |
| ***ҮАГ*** | Үндэсний аудитын газар |
| ***ХБТХОХ*** | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


| | |
|---|---|
| *Хүснэгт 1* | *Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг /сая төг/* |
| *Хүснэгт 2* | *ОНХНС-ийн санхүүжилтийн сарын хуваарь /сая.төг/* |
| *Хүснэгт 3* | *Сумдад олгосон ОНХС-ийн санхүүжилтийн хуваарь /сая.төг/* |
| *Хүснэгт 4* | *Сумуудын малын тоо толгойн албан татварын үнэлгээ /төгрөгөөр/* |
| *Хүснэгт 5* | *Сумуудын 2021 оны сүүлийн хагас жилийн малын тоо толгойн албан татварын төлөвлөлт, гүйцэтгэл /сая.төг/* |
| *Хүснэгт 6* | *Зарим сумдын 2021 оны ОНХС-ын төлөвлөлтийн шатанд иргэдийн оролцоог хангасан байдал* |
| *Хүснэгт 7* | *Зарим сумдын 2021 оны ОНХС-ын төлөвлөлтийн шатанд БИНХ-д иргэдийн оролцооны байдал* |
| *Хүснэгт 8* | *Бодлогын баримт бичгийн жагсаалт* |
| *Хүснэгт 9* | *Аймаг, зарим сумдын ОНХС-ын төлөвлөлтийн шатанд шийдвэрлэх асуудлыг тусгасан жагсаалт* |
| *Хүснэгт 10* | *Гэрээний хугацаа хойшилсон ажлуудын жагсаалт* |
| *Хүснэгт 11* | *Сумдын ИТХ-ын хяналтын хорооноос иргүүлсэн хяналтын тайлангийн хэрэгжилт* |
| *Хүснэгт 12* | *Өвөрхангай аймгийн сумдын 2019-2021 оны ЖГҮ-ний үр дүн ба урамшууллын хэмжээ /сая.төг/* |
| *Хүснэгт 13* | *Өвөрхангай аймгийн 2021 оны сумдын ЖГҮ-ний үр дүн, бүлгээр* |
| *Хүснэгт 14* | *Санхүүгийн тайланд бүртгээгүй урьдчилж төлсөн зардлын дүн* |
| *Хүснэгт 15* | *Удирдлагын мэдээллийн системд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтийг оруулсан байдал /сая. төг/* |
| *Хүснэгт 16* | *ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг УМС-д оруулсан байдал /сая.төг/* |
| *Хүснэгт 17* | *ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байдал /сая.төг/* |


## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ


| | |
|---|---|
| *График 1* | *ОНХС-ийн ажилд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас хийсэн захиалагчийн хяналт* |
| *График .* | *ОНХС-ийн ажилд ХБТХОХ-ийн хийсэн захиалагчийн хяналт* |


## ЗУРГИЙН ЖАГСААЛТ


| | |
|---|---|
| *Зураг 1.* | *Цэвэр усны эх үүсвэрт давсны уусмалын халдваргүйжүүлэх тоног төхөөрөмж* |
| *Зураг 2.* | *Хархорин суманд хийгдсэн ухаалаг худгийн тоног төхөөрөмж* |
| *Зураг 3.* | *Төгрөг сумын газар тариалангийн тоног төхөөрөмж* |
| *Зураг 4.* | *Баянгол сумын Сум тохижилтын ажил* |
| *Зураг 5.* | *Гучин-Ус сумын 10 га газар хашаалсан* |
| *Зураг 6.* | *Бат-Өлзий суманд хийгдсэн хайс* |
| *Зураг 7.* | *Зүүнбаян-Улаан суманд хийгдсэн явган хүний зам* |
| *Зураг 8.* | *Бат-Өлзий сумын хайс* |
| *Зураг 9.* | *Хархорин сумын тоглоомын талбай* |

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэв.

**Аудитын зорилт**

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан ҮАГ болон холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

**Аудитын хамрах хүрээ**

Аймгийн ОНХС-ийн 2021 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал болон аймгийн ЗДТГ, аймгийн ГХБХБГ, аймгийн Орон нутгийн өмчийн газар болон 19-н сумдын ИТХ, ЗДТГ, баг, хороодын ИНХ, Засаг даргын холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгасан.

**Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж баримтжуулан аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд**

Дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.
Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/;

- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- МУ-ын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал"
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"
- Сангийн сайдын 2018 оны 288 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

**Аудит хийх бүрэлдэхүүн**

Аудитыг Өвөрхангай аймаг дахь ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал удирдан, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Гансүх хэрэгжүүлж, ахлах аудитор П.Хорлоосүрэн, аудитор Ө.Ринчинмядаг, Э.Энхбаяр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

## Ерөнхий мэдээлэл:

Төсвийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааны журам"-ыг мөрдөж байсан бөгөөд Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг шинэчлэн баталсан журам зэргийг мөрдөж ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/07 тогтоолоор сумдын ОНХС-ийн хөрөнгийг 2,848.5 сая төгрөгөөр, аймгийн ОНХС-ийн хөрөнгийг 4,519.1 сая төгрөгөөр нийт 7,367.6 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 05/07 тоот тогтоолоор сумдын ОНХС-ийн хөрөнгийг 2,951.6 сая төгрөгөөр, аймгийн ОНХС-ийн хөрөнгийг 4,759.5 сая төгрөгөөр нийт 7,711.2 сая төгрөг буюу 343.5 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

ОНХНС-аас 6,870.6 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс 840.6 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

*Хүснэгт 1. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг /сая төг/*

| № | Сумдын нэр | 2020.12.03-ны тогтоолоор | | | | | Тодотголоор |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Урамшуулал | ОУТ, хөтөлбөр | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл | Итгэлцүүрээр хуваарилсан | Бүгд | |
| 1 | Баян-Өндөр | 28 | 7.1 | 87.2 | 74.4 | 196.7 | 201.1 |
| 2 | Бүрд | 22.8 | 5.7 | | 61.5 | 90.0 | 93.7 |
| 3 | Бат-Өлзий | 54.3 | 10.9 | 20.2 | 119.9 | 205.3 | 212.6 |
| 4 | Баруунбаян-Улаан | 28.4 | 7.2 | 11.8 | 77.4 | 124.8 | 129.5 |
| 5 | Баянгол | 26 | 6.6 | 13.7 | 69.9 | 116.2 | 120.4 |
| 6 | Гучин-Ус | 30 | 6.1 | 0 | 65.5 | 101.6 | 105.5 |
| 7 | Есөнзүйл | 25.1 | 5.1 | 0 | 52.5 | 82.7 | 85.8 |
| 8 | Өлзийт | 15.4 | 3.9 | 0 | 41.3 | 60.6 | 63.1 |
| 9 | Зүүнбаян-Улаан | 26.4 | 5.4 | 1.1 | 55.7 | 88.6 | 91.9 |
| 10 | Богд | 83.2 | 16.8 | 41.1 | 182.8 | 323.9 | 334.8 |
| 11 | Нарийнтээл | 33.3 | 6.8 | 32.2 | 71.6 | 143.9 | 148.1 |
| 12 | Сант | 23.4 | 5.9 | 0 | 63.3 | 92.6 | 96.3 |
| 13 | Тарагт | 25.2 | 5.1 | 42.4 | 53.2 | 125.9 | 129.1 |
| 14 | Төгрөг | 28.2 | 7.1 | 2.1 | 76.2 | 113.6 | 118.2 |
| 15 | Уянга | 0 | 10.9 | 18.5 | 116.4 | 145.8 | 152.7 |
| 16 | Хайрхандулаан | 32.1 | 6.5 | 10.7 | 69.5 | 118.8 | 122.8 |
| 17 | Хужирт | 40 | 8.1 | 0 | 87.7 | 135.8 | 141.1 |
| 18 | Хархорин | 88.4 | 17.9 | 0 | 190.4 | 296.7 | 308.1 |
| 19 | Арвайхээр | 69.7 | 17.6 | 0 | 197.7 | 285.0 | 296.8 |
| **Сумдын дүн** | | **679.9** | **160.7** | **281** | **1726.9** | **2848.5** | **2951.6** |
| Аймгийн ОНХС | | | | | | 4,029.7 | 4,270.2 |
| ОНХС-аас санхүүжих суурь зардал | | | | | | 489.4 | 489.4 |
| **Нийт дүн** | | | | | | **7,367.6** | **7,711.2** |

Сумууд ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай үйлчлэх зорилгоор ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс санхүүжүүлэн Сангийн яамны цахим хуудсанд байршуулсан “Удирдлагын мэдээллийн систем”-д оруулан ажиллаж байна.

Аудитаар 13,580.5 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 16 төрлийн 307.9 сая төгрөгийн акт, 43 төрлийн 13,272.5 сая төгрөгийн аалбан шаардлага, 151 төрлийн 6,241.6 сая төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлэв.

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРИМ ХӨРӨНГИЙН ЧАНАР, АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ ХАНГАЛТГҮЙ, УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ БОЛОН ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДСАНД МЭДЭЭЛЛЭЭ БҮРЭН БАЙРШУУЛААГҮЙ БАЙНА**

## 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БАЙНА

### 1.1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарийн дагуу санхүүжилтээ олгосон болович малын тоо толгойн албан татварыг дутуу төвлөрүүлсэн байна.

#### 1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэр бүрдүүлэлт аймагт хамааралгүй болно

Орон нутгийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг Сангийн яаманд тооцож байгаа тул эх үүсвэрийн төлөвлөлтийг орон нутагт үзэх боломжгүй байна.

#### 1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль, журмыг баримталж хуваарилан олгосон байна

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлд үндэслэн хуваарилсан байна. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэхдээ ОНХНС-аас итгэлцүүрээр хуваарилан 6,870.4 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа-3 төслийн дэмжлэг 840.7 сая төгрөг нийт 7,711.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

*Хүснэгт 2. ОНХНС-ийн санхүүжилтийн сарын хуваарь /сая.төг/*

| Сар | ОНХНС-ийн орлогын төлөвлөлт | ОНХНС-аас олгосон санхүүжилт | Зөрүү |
|---|---|---|---|
| **1** | | | |
| **2** | 312.3 | 155.9 | 156.4 |
| **3** | 499.7 | 313.6 | 186.1 |
| **4** | 680.8 | 486.0 | 194.8 |
| **5** | 1465.2 | 1500.6 | -35.4 |
| **6** | 499.7 | 517.3 | -17.6 |
| **7** | 694.8 | 338.6 | 356.2 |
| **8** | 499.7 | 1032.8 | -533.1 |
| **9** | 1261.5 | 728.3 | 533.2 |
| **10** | 602.9 | 11.1 | 591.8 |
| **11** | 499.7 | 1346.4 | -846.7 |
| **12** | 694.8 | 1280.5 | -585.7 |
| **Дүн** | **7711.1** | **7711.1** | **0** |

Дээрх хүснэгтээс харахад оны эхний 7 сард санхүүжилт хуваариас дутуу орж ирсэн ба 8, 11,12 сард дутуу санхүүжилтийг гүйцээн бөөн дүнгээр орж иржээ.

Энэ нь аймгийн ОНХС-ийн эх үүсвэр болох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан Сангийн яамны санхүүжилт орж ирсэн байна.

#### 1.1.3. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгожээ

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 05/07 тоот тогтоолоор 7,367.6 сая төгрөг, тодотголоор 7,711.2 сая төгрөг болгон батлагдсанаас сумдад 2,951.6 сая төгрөгийг хуваарилсан байна.

*Хүснэгт 3. Сумдад олгосон ОНХС-ийн санхүүжилтийн хуваарь /сая.төг/*

| Сар | ОНХС-ийн орлогын төлөвлөлт | ОНХС-аас олгосон санхүүжилт | Зөрүү |
|---|---|---|---|
| 1 | 0 | 0 | 0 |
| 2 | 156 | | 156 |
| 3 | 123 | 279 | -156 |
| 4 | 291 | 291 | 0 |
| 5 | 903.2 | 840.6 | 62.6 |
| 6 | 177.8 | 177.8 | 0 |
| 7 | 199.7 | 199.8 | -0.1 |
| 8 | 199.8 | 199.8 | 0 |
| 9 | 302.9 | 199.8 | 103.1 |
| 10 | 199.8 | 302.9 | -103.1 |
| 11 | 199.8 | 199.8 | 0 |
| 12 | 198.6 | 261.1 | -62.5 |
| | 2951.6 | 2951.6 | 0 |

Дээрх хүснэгтээс харахад сумдын ОНХС-ийн санхүүжилтийг хуваарийн дагуу олгож ирсэн байна.

### 1.1.4. Сумууд ОНХС-д хуулиар олгогдох эх үүсвэр болох малын тоо толгойн албан татварын орлогыг орон нутгийн хөгжлийн санд бүрэн төвлөрүүлээгүй байна

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “д”, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумууд малын тоо толгойн албан татварын жишиг тогтоож, татварын орлогыг 2021 оны 7 дугаар сарын 1-ээс эхлэж ногдуулж 2022 оноос эхлэж төлөвлөсөн байна. Сумууд малын тоо толгойн албан татварын ногдлыг өөр өөр тогтоосон байна.

*Хүснэгт 4. Сумуудын малын тоо толгойн албан татварын үнэлгээ /төгрөгөөр/*

| № | Сумдын нэр | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Баян-Өндөр | 300 | 1000 | 500 | 500 | 1000 |
| 2 | Бүрд | 1000 | 1000 | 500 | 500 | 1000 |
| 3 | Бат-Өлзий | 0 | 1000 | 800 | 500 | 1500 |
| 4 | Баруунбаян-Улаан | 300 | 500 | 300 | 500 | 800 |
| 5 | Баянгол | 500 | 1000 | 800 | 800 | 1000 |
| 6 | Гучин-Ус | 600 | 1000 | 600 | 800 | 1000 |
| 7 | Есөнзүйл | 500 | 1000 | 500 | 500 | 1000 |
| 8 | Өлзийт | 0 | 500 | 400 | 300 | 500 |
| 9 | Зүүнбаян-Улаан | 500 | 1000 | 800 | 800 | 1000 |
| 10 | Богд | 500 | 800 | 800 | 500 | 800 |
| 11 | Нарийнтээл | 500 | 1000 | 800 | 800 | 1500 |
| 12 | Сант | 250 | 800 | 500 | 500 | 800 |
| 13 | Тарагт | 0 | 400 | 250 | 300 | 550 |
| 14 | Төгрөг | 200 | 500 | 400 | 500 | 1000 |
| 15 | Уянга | 0 | 1000 | 1000 | 1000 | 2000 |
| 16 | Хайрхандулаан | 600 | 1000 | 600 | 600 | 1200 |
| 17 | Хужирт | 0 | 1000 | 600 | 600 | 1200 |
| 18 | Хархорин | 500 | 1000 | 500 | 800 | 1500 |
| 19 | Арвайхээр | 800 | 1500 | 800 | 500 | 1500 |

Сумууд дээрх үнэлгээгээр малын тоо толгойн албан татварын 2021 оны сүүлийн хагас жилийн орлого болон 2022 оны орлогыг ОНХС-ийн 2022 оны төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд төлөвлөсөн байна.

*Хүснэгт 5. Сумуудын 2021 оны сүүлийн хагас жилийн малын тоо толгойн албан татварын төлөвлөлт, гүйцэтгэл /сая.төг/*

| № | Сумдын нэр | 2021 оны сүүлийн хагас жилд ногдуулсан татвар | Төсөвт төвлөрүүлсэн татвар | Төсөвт төвлөрүүлээгүй татвар |
|---|---|---|---|---|
| 1 | Арвайхээр | 105.8 | 93.9 | 11.9 |
| 2 | Баруунбаян-Улаан | 32.6 | 30.6 | 2.0 |
| 3 | Бат-өлзий | 113.4 | 95.0 | 18.4 |
| 4 | Баянгол | 128.4 | 111.1 | 17.3 |
| 5 | Баян-Өндөр | 95.1 | 61.7 | 33.4 |
| 6 | Богд | 82.7 | 78.2 | 4.5 |
| 7 | Бүрд | 98.4 | 62.7 | 35.7 |
| 8 | Гучин-Ус | 48.0 | 28.2 | 19.8 |
| 9 | Есөнзүйл | 59.7 | 47.5 | 12.2 |
| 10 | Зүүнбаян-Улаан | 105.5 | 91.4 | 14.1 |
| 11 | Нарийнтээл | 96.1 | 96.1 | 0 |
| 12 | Өлзийт | 31.7 | 19.6 | 12.1 |
| 13 | Сант | 67.5 | 69.9 | 0 |
| 14 | Тарагт | 40.4 | 0 | 0.0 |
| 15 | Төгрөг | 53.6 | 42.3 | 11.3 |
| 16 | Уянга | 175.7 | 110 | 65.7 |
| 17 | Хайрхандулаан | 93.2 | 83.2 | 10.0 |
| 18 | Хархорин | 143.0 | 125.8 | 17.2 |
| 19 | Хужирт | 95.5 | 73.2 | 22.3 |
| | Дүн | **1668.7** | **1320.4** | **307.9** |

Дээрх судалгааг сумуудын 2021 оны жилийн эцсийн мал тооллогын статистик дүн мэдээнээс малын тоог авч, сумдын нэг малд ногдох албан татварын үнэлгээгээр тооцож гаргасан.

Сумууд 2021 оны сүүлийн хагас жилийн малын тоо толгойн албан татварын орлого 1,668.7 сая төгрөг төлөвлөснөөс 1,320.4 сая төгрөгийн орлого оруулж, 307.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлээгүй байна. Тарагт сум тухайн онд татвараас бүрэн чөлөөлсөн байна. Сумууд 2021 оны жилийн эцэст малын тоо толгойн албан татварын орлогыг сумын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн боловч 2022 оноос ОНХС-нд татан төвлөрүүлж байна.

Аймаг, сумууд ОНХС-д хуулиар олгогдсон бусад эх үүсвэрээс орлого орох боломж байхгүй байна.

## 1.2. Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог бүрэн хангаагүй, орон нутгийн хөгжлийн бодлоготой бүрэн уялдуулаагүй байна

### 1.2.1. Төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг тэгш хүртээмжтэй аваагүй, ач холбогдол, саналын тоогоор эрэмбэлэх ажил хангалтгүй байна

ОНХС-аас хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг иргэдээс авч эрэмбэлэх, БИНХ-аар төслийг хэлэлцэн батлахад дараах байдлаар иргэдийн оролцоог хангана гэж заасан байдаг. Үүнд:

***Нэгдүгээр шат-*** Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.-д “Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг дараах хэлбэрээр явуулна.” ***/Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар хүчингүй болсон./***

**1. Санал асуулгын хуудас**

- Санал асуулгын хэлбэрээр иргэдээс мэдээлэл авахдаа холбогдох журамд заасан “санал авах маягт”-ыг ашиглан багийн өрх бүрд хүргүүлж, тэдний саналыг авна.

**2. Бүлгийн хэлэлцүүлэг**

- Зохион байгуулалттай бүлгийн хувьд 50-аас доошгүй иргэн, алслагдсан багийн хувьд 30-аас доошгүй иргэний бүрэлдэхүүнтэй байх ба бүлгийн ярилцлага, хэлэлцүүлгийг жилд хоёроос доошгүй удаа хийсэн байна. Жишээ нь: хот айл, ойролцоо нутагладаг иргэд тус бүр сонирхлын бүлгээрээ нэгдэж, ОНХС-ийн төслийн саналаа хэлэлцэж, тэмдэглэл хөтлөн, өөрсдийн төлөөллөө сонгон багийн ИНХ-д илгээж болно.

**3. Цахим хэлбэр**

- Цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэр (цахим шуудан, гар утасны мессеж г.м)

***Хоёрдугаар шат-*** Иргэдээс ирүүлсэн нийт саналын жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг явуулна. Хурлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10[1]-т заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 5 дугаар сард багтаан зохион байгуулна гэж “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан байна.

**Сумын ОНХС-** Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3[2]-д санал авах маягтыг өрх бүрд хүргүүлнэ гэж заасан бөгөөд энэхүү заалтын хүрээнд өрхөд саналын хуудас хүргүүлсэн тоог нийт өрхийн тоонд харьцуулан хамрагдалтыг зарим сумдын саналыг түүвэрлэн харьцуулан үзвэл:

*Хүснэгт 6. Зарим сумдын 2021 оны ОНХС-ын төлөвлөлтийн шатанд иргэдийн оролцоог хангасан байдал*

| № | Сумын нэр | Багийн тоо | Өрхийн тоо | Нийт саналын хуудас хүргүүлсэн өрхийн тоо | Саналын хуудас хүлээн авсан өрхийн эзлэх дундаж хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Арвайхээр | 13 | 9022 | 2304 | 26% |
| 2 | Баян-Өндөр | 5 | 1141 | 456 | 40% |
| 3 | Өлзийт | 4 | 741 | 318 | 46% |
| 4 | Сант | 5 | 1060 | 316 | 30% |
| 5 | Уянга | 8 | 2778 | 1359 | 49% |
| 6 | Нарийнтээл | 4 | 1005 | 509 | 48% |
| **Дундаж хувь** | | | | | 40% |

Дээрх хүснэгтээс үзэхэд анхан шатны санал хураалтын хүрээнд өрхүүдэд төдийлөн хангалттай саналын хуудсыг хүргээгүй байна. Арвайхээр сумын багуудын саналын хуудаснаас харахад зөвхөн нэг төвлөрсөн хэсгийн байруудыг хамруулсан байгаа нь тэгш хүртээмжтэй байдлаар иргэдийн саналыг аваагүй байна.

*Тогтвортой амьжиргаа төслөөс иргэдийн олонхын санал авсан арга хэмжээ тусгагдсан эсэхийг шалгадаг. Хурлын тэмдэглэлээс үзэхэд шалгалт ирэхээр л*

[1] 23.10. “Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.” /2020 оны 12 сарын 24-ны өдрийн шинэчилсэн найруулгаар хүчингүй болсон./

[2] 5.3. “Энэ журмын 5.2.1-д заасан хэлбэрээр санал авахдаа энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан жишиг маягтыг баг, хорооны өрх бүрд хүргүүлж,бүртгэл хөтлөн ирсэн саналыг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж нэгтгэнэ.”

*Арвайхээр сумаас багуудын Засаг дарга нартай ярьж санал эрэмбэлэхдээ засдаг байна. /2020 оны баримт үдэж, архивлагдаагүй, дутуу байна/*

Иргэдээс авсан саналын дагуу урьдчилсан жагсаалт бэлтгэн эрэмбэлсний дараа эрэмбэлэгдсэн саналуудыг Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар хавсралтаар баг, хорооны ИНХ-аар батлагдсан төслийн танилцуулгад сумын тэргүүлэх чиглэлийн салбарт үндэслэн төслийн хамрах хүрээг тодорхойлон маягтыг бөглөн баталгаажуулдаг. Зарим сумдын маягт хөтлөлтөөс үзэхэд тэргүүлэх чиглэлийг бүрэн бөглөөгүй /байгаль орчинд ээлтэй, багаас тогтоосон цэгт, багийн нутаг дэвсгэр/ байгаа нь багийн Засаг дарга нарын ойлголт муу байгаатай холбоотой.

Аймаг, сумуудын нийт 85501 иргэнээс санал авч 508 төсөл, хөтөлбөр дээр 15,782.3 сая төгрөгийн санал эрэмбэлэгдэж, 231 төсөл, хөтөлбөрийн 8,685.9 сая төгрөгийн ажил батлагдаж, 7,096.4 сая төгрөгийн 277 ажил нь батлагдаагүй байна.

Арвайхээр сумын хувьд цахим болон бүлгийн ярилцлагын хэлбэрээр тодорхой тооны иргэдээс саналыг авч ажилласан байна.

Мөн тус журмын 5 дугаар зүйлийн 5.8.-д “Баг, хорооны ИНХ-ын дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 5 дугаар сард багтаан зохион байгуулна.” гэж заасны дагуу хоёрдугаар шатны санал хураалтын оролцоог дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 7. Зарим сумдын 2021 оны ОНХС-ын төлөвлөлтийн шатанд БИНХ-д иргэдийн оролцооны байдал*

| № | Сумын нэр | Өрхийн тоо | Өрхийн тоонд харьцуулсан хүчин төгөлдөр ирц | БИНХ-д оролцон санал өгсөн иргэний тоо | Хоёр үзүүлэлтийн харьцуулсан хувь | Хүчин төгөлдөр ирц-Бодит ирц зөрүү |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Арвайхээр | 9022 | 301 | 408 | 136% | -107 |
| 2 | Баян-Өндөр | 1141 | 285 | 127 | 45% | 158 |
| 3 | Өлзийт | 741 | 185 | 378 | 204% | -193 |
| 4 | Сант | 1060 | 265 | 352 | 133% | -87 |
| 5 | Уянга | 2778 | 695 | 64 | 9% | 631 |
| 6 | Нарийнтээл | 1005 | 251 | 76 | 30% | 175 |
| **Дундаж хувь** | | | 330 | 234 | 93% | 96 |

Дээрх хүснэгтээс харахад сумдын хувьд БИНХ-ын ирц харилцан адилгүй Уянга-9, Нарийнтээл-30, Баян-Өндөр -45 хувь буюу хүчин төгөлдөр ирц бүрдээгүй нөхцөлд хурлыг зохион байгуулж иргэдийн саналыг эрэмбэлсэн байна.

Дээрх 2 үндсэн үе шатанд анхан шатны маягтын хөтлөлтийн хувьд тоон дүн зөрүүтэй, саналын маягтууд бүрэн бөглөгдөөгүй зэрэг нийтлэг алдаа зөрчлүүд байна. Үүнд:

- Өрхөд саналын хуудас хүргүүлсэн жагсаалт үйлдээгүй.
- БИНХ-ын ирцийн бүртгэл байхгүй.
- Орон нутгийн хөгжлийн сангийн иргэдээс санал авах маягтын 2 дугаар хавсралт “Санал асуулгын хуудсаар авсан төслийн саналын жагсаалт”-д бичигдсэн өрхийн тоо цаасан саналын хуудасны тоотой зөрүүтэй байх.

Дээрх алдаа, зөрчлүүдээс үзэхэд анхан шатны нэгж болох баг дээр иргэдээс ирж буй саналын эрэмбэлэх ажил хангалтгүй байна.

Сумын түвшинд батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтаас харахад ихэнх хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь сумын төвийн багуудаас гарсан санал зонхилж байна. Баг бүрээс санал авдаг боловч сумын төвийн багийн хүн ам бусад багуудаас их, мөн санал асуулгын хуудаст- “Сум/дүүргийн хөгжлийн бодлого,

төлөвлөлттэй уялдуулан сум/дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дараах байршилд ....... онд хийгдэх ажлыг дэмжиж байгаа эсэх" гэсэн хэсэгт түлхүү сумын төвд хийгдэх боломжтой ажлуудыг төвийн, алслагдсан бүх багийн саналын хуудаст тусгаж өгсөн байна. Энэ нь нийт багуудын жигд оролцоо хангалтгүй байгааг харуулж байна.

Мөн санал авах ажлын хэсэг саналын хуудасны "Сум/дүүргийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан сум/дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дараах байршилд ....... онд хийгдэх ажлыг дэмжиж байгаа эсэх" гэсэн хэсэгт төсөл, арга хэмжээний жагсаалтуудыг бүрэн оруулж өгдөггүй байна.

ОНХС-ийн журмын 3 дугаар зүйлийн 3.1.-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дараах нөхцөлүүдийг хангасан байна.", 3.1.2.-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх" гэсэн заалтыг зөрчин дараах сумдад иргэдийн санал аваагүй ажлууд хийгдсэн байна. Үүнд:

Арвайхээр сум

1. Зах зээл ба бэлчээрийн удирдлага Хүнсний зоорь барих ажлын 30 хувь буюу 37.0 сая төгрөг

Бүрд сум

1. Спорт заал, Залуучуудын хөгжлийн төвийн дулааны шугамын засвар 20.0 сая төгрөг
2. Хүүхдийн тоглоомын талбай 20.0 сая төгрөг
3. Сургуулийн биеийн тамирын зааланд бөхийн дэвжээ 3.4 сая төгрөг.

Өлзийт сум

1. Гэр хорооллын гудамжны засвар 9.8 сая төгрөг
2. Соёлын төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх 9.0 сая төгрөг
3. Цэцэрлэгт хүрээлэнгийн засвар 9.8 сая төгрөг

**Аймгийн ОНХС-**Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1[3] -д заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын ХБТХОХ-ийн дарга Г.Баясгалангаар ахлуулсан, 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлын урьдчилсан жагсаалтыг боловсруулсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын хувьд Арвайхээр сумаас ирүүлсэн 18, Хархорин сумаас ирүүлсэн 1 нийт 19-н ажлаас эрэмбэлж 8-н ажлыг урьдчилсан жагсаалтад оруулсан байна.

Сангийн журмын 7 дугаар зүйлийн 7.5[4]-д урьдчилсан жагсаалтын нээлттэй хэлэлцүүлгийг 2-с доошгүй удаа зохион байгуулна гэж заасан бөгөөд 2020 онд тус хэлэлцүүлгийг 1 удаа явуулсан байна. Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Ганболдын баталсан 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн удирдамжаар "Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэн 2021 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналд иргэн таны оролцоо" сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг 2020 оны 08 дугаар сарын 02-нд зохион байгуулсан байна.

[3] 7.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан,холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулан, 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

[4] 7.5.Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 7 дугаар сард багтаан 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

Энэхүү хэлэлцүүлэгт аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Засаг даргын Тамгын газрын ХБТХОХ-ийн дарга, ажлын хэсэг, Арвайхээр сумын 13 багийн Засаг дарга, иргэдийн төлөөлөл оролцсон бөгөөд бүртгэлээр нийт 109 иргэн хэлэлцүүлэгт оролцсон байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

1. Уянга сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн сантехникийн их засвар 200.0 сая төгрөг
2. “Дэлгэрэх гол төсөл” 300.0 сая төгрөг
3. Нийгмийн эрүүл мэндийн төвийн агуулах 176.0 сая төгрөг
4. Хужирт сумын Төрийн албан хаагчийн албан хэрэглээний байр 150.0 сая төгрөг
5. Тарагт сумын нийтийн худалдааны зах 60.0 сая төгрөгийн санхүүжилтээс Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс 42.0 сая төгрөгийг, сумын ОНХС-ийн хөрөнгөнөөс 18.0 сая төгрөг
6. Зураг төсөв хийх ажилд 58.7 сая төгрөг
7. Арвайхээр сумын 7 дугаар цэцэрлэгийн их засвар 150.0 сая төгрөг байна.

**Багийн Засаг дарга нараас авсан судалгааны үр дүнгээс:**

1. ОНХС-ын төлөвлөлттэй холбоотой үүсдэг нийтлэг хүндрэлтэй асуудал?
- ОНХС-ийн санал авах үйл ажиллагаа нь хэлбэр төдий болсон. Багт дээгүүр эрэмбэлэгддэг чухал ажлууд, нийт массын төвшинд дээгүүр эрэмбэлэгдэж чаддаггүй
- Иргэдээс гарсан санал ажил хэрэг болдоггүй.
- Иргэдийн идэвх оролцоо буурсан.

2. ОНХС-ийн санал асуулгын хуудсыг багийн өрх бүрд хүргүүлж ажиллаагүй гол шалтгаан?
- Иргэдийн ОНХС-ийн талаар ойлголт муу, ач холбогдол өгөхөө больсон, саналын хуудас хүргүүлсэн ч бөглөдөггүй.
- Асуулга нь ойлгомжтой бус.
- Ковид-19-ын нөхцөл байдал
- Ойрын жилүүдэд малчид отор нүүдэлд явж тарсан.

3. БИНХ-д иргэдийн ирц бага байсан шалтгаан?
- Мөн л иргэдийн итгэлгүй байдал. Бидний гаргасан санал ажил хэрэг болох биш дээ гэсэн үзлээр ханддаг. Иргэдийн санал болгож эрэмбэлүүлсэн ажил хэрэгжихгүй учраас
- Иргэдийн идэвх муу залуу, дунд үеийнхэн БИНХ-д оролцдоггүй.

4. Сумын Засаг дарга нь ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлын жагсаалтад иргэдийн өгсөн санал багтсан болон багтаагүй шалтгааныг мэдээлдэг эсэх?

Тийм, үгүй гэсэн хариултаас үзэхэд зарим тохиолдолд мэдээлдэггүй гэсэн үр дүн харагдаж байна.

Дээрх судалгаанаас үзэхэд иргэдийн идэвх оролцоо санал асуулга, хурлын ирцэд мөн тодорхой хэмжээнд нөлөөтэй байгааг харуулж байна. Санал асуулгаас дүгнэлт хийхэд багийн Засаг дарга нар иргэдийг мэдээллээр хангах хувилбар, сайн туршлагууд хэрэгжүүлж оролцоог сайжруулах тал дээр илүү сайн арга хэмжээ авах шаардлагатай байна.

### 1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй төдийлөн уялдуулахгүй байна

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2021 оны ажлуудын төлөвлөлт 2020 онд хийгдсэн тул аудитын хүрээнд Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын шалгуур заалтуудад үндэслэв.***/Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар хүчингүй болсон/***

Сангийн журмын 3 дугаар зүйлийн 3.1.1-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;" гэж заасан. Тус хуульд зааснаар дараах бодлогын баримт бичгүүд аймаг, сумын түвшинд хамаарна. Үүнд:

*Хүснэгт 8. Бодлогын баримт бичгийн жагсаалт*

| № | Бодлогын баримт бичгийн төрөл | Аймаг | Сум |
|---|---|---|---|
| 1 | Урт | **АЛСЫН ХАРАА-2050** /30 жилийн хугацаанд хэрэгжүүлэх/ | |
| 2 | Дунд | Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх *таван* жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр | |
| 3 | Богино | Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв | |

Аймаг, сумуудын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь эдгээр баримт бичгүүдийн тэргүүлэх чиглэлтэй уялдаж байх ёстой.

"Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг баталсан аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны 03/02 тогтоол, "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны 03/03 дугаар тогтоолоор тус тус батлагдсан. Сумдын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3[5]-д заасны дагуу үйл ажиллагааны хөтөлбөрүүд батлагджээ. Аймаг, сумуудын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хийгдэх ажлуудыг төлөвлөлтийн шатанд урьдчилсан жагсаалтыг хэлэлцүүлэх үйл ажиллагаа 2022 оны 5-8 дугаар сарууддад хийгдсэн байна.

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тулгуурлах боломжгүй, 2020-2024 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдаагүй байсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хийгдэх ажлыг эрэмбэлэх ажлын хэсгийн хурлын тэмдэглэлээс үзэхэд бодлогын баримт бичгүүдэд нийцэж байгаа эсэхийг төдийлөн харгалзаж үзээгүй байна. Мөн урьдчилсан жагсаалтыг бэлтгэхдээ жилийн хөгжлийн хөтөлбөр, урт хугацааны баримт бичгийн уялдааг бус хамрах хугацаа дууссан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн уялдааг авч үзсэн байна.

### 1.2.3. Аймаг, сумын ОНХС-аас Засаг даргын чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг тусгасан байна

Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх болон санхүүжүүлэхийг хориглосон чиг үүргийг дараах байдлаар заасан байна.

[5] 17.3.Сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна.

| **ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРГҮҮД (барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар)** | **ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОСОН ЧИГ ҮҮРГҮҮД:** |
|---|---|
| ***1.*** Сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах;<br>***2.*** Сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгаа хийх, зохион байгуулах;<br>***3.*** Сумын тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбай тохижуулах, арчлах;<br>***4.*** Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх;<br>***5.*** Сумын мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;<br>***6.*** Сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулах ажлыг хийх;<br>***7.*** Сумын усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх;<br>***8.*** Сумын орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх | ***1.*** Сумын удирдлагыг хэрэгжүүлэх зардал.<br>***2.*** Улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага;<br>***3.*** Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;<br>***4.*** Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;<br>***5.*** Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;<br>***6.*** Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.<br>***7.*** Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал<br>***8.*** Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн болон урсгал зардал |

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу иргэдээс санал авсны дараа тус журмын 5 дугаар хавсралтын дагуу багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх төслийн саналын урьдчилсан жагсаалт бэлтгэх бөгөөд тус жагсаалтыг бэлтгэхдээ ОНХС-аас санхүүжүүлэхийг хориглосон зүйлийг хүснэгтэд оруулахгүй гэж журамд заасан. Түүвэрт хамрагдсан сумдаас урьдчилсан жагсаалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг хориглосон чиг үүргүүд бүхий дараах ажлуудыг тусгажээ. Үүнд:

- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих
- Мал маллах хүмүүсийг малжуулах
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг төсөл хөтөлбөрөөр хангах
- Шөнийн тоолуур тавих
- Ахмад настан иргэдэд зориулсан түрээсийн орон сууц барих
- Мод бутны суулгацыг иргэдэд үнэ төлбөргүй олгож, ногоон байгууламж нэмэгдүүлэх
- Таксины үнийг бууруулах, тогтсон тарифтай болгох
- Мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулж, тоног төхөөрөмжөөр хангах

Иргэдээс ийм саналууд гарч байгаа нь Багийн Засаг дарга нар /сумын ЗДТГ-тай хамтрах/ иргэдэд дараах мэдээллүүдийг хангалттай хүргэхгүй байгаатай холбоотой. Үүнд:

- ОНХС-ийн зорилго, түүний ач холбогдол бүхий танилцуулга
- Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөр
- Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

- Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг хориглосон болон зөвшөөрсөн зүйлсийн жагсаалт.

#### 1.2.4. Аймаг, сумдын түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг холбогдох хууль журмын дагуу төлөвлөсөн байна

Аймаг, сум, багийн түвшинд Төсвийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиудын заалтыг үндэслэн төлөвлөж ирсэн байна.

## 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ИХЭНХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ЗАРИМ ХӨРӨНГИЙН ЧАНАР, АШИГЛАЛТ,ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

### 2.1 Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан боловч зарим ажил зориулалт бусаар зарцуулагдсан байна

#### 2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна

Аймгийн орон нутгийн өмчийн газраас ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих 8 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулжээ. Үүнд:

- Арвайхээр сумын гудамж талбайн тохижилтын ажил нийт 15 багц болгон зарласан ба 13,15-р багц дээр оролцогч санал ирүүлээгүй байна.
- Нийгмийн эрүүл мэндийн төвийн агуулах барих ажилд 2 компани оролцсон байна.
- Нисэхийн зүүн талын 1 км урттай автозамын шинэчлэлийн ажилд 2 компани оролцсон.
- Дэлгэрэх голын гольдролын тохижилтын ажилд 1 компани оролцсон байна.
- Ковид цар тахалтай холбоотой тоног төхөөрөмж худалдан авах ажлыг 2, 3 багц болгон зарлаж, 2-р багц дээр 3 компани, 3-р багц дээр 7 компани оролцсон байна.
- Аймгийн Наадмын талбайн засварын ажлыг 5 багц болгон зарласан байна.
- Арвайхээр сумын хуучин орон сууцны дээвэр засварын ажилд 2 компани оролцсон
- Тарагт сумын үйлчилгээний төвийн барилгын ажилд 1 компани тус тус санал ирүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн зарим ажил нь суманд эрх шилжүүлж тендер зарлагдсан. Үүнд :

- Хужирт сумын төрийн албан хаагчдын албан хэрэгцээний байр барих
- Хархорин сумын гудамж талбайн засвар, шинэчлэлийн ажил байна.

Хархорин сумын гудамж, хашаа тохижуулах ажил нь 2021 оны 6 дугаар сарын 03-нд “Хуримт констракшн” ХХК, “Рашбай” ХХК тендерийн материалаа ирүүлж хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Хуримт констракшн” ХХК-ийг шалгаруулсан байна. “Рашбай” ХХК нь шалгарсан компани үнийн саналыг маягтын дагуу ирүүлээгүй, татварын тодорхойлолт уг тендерийн шалгаруулалтад биш зэрэг шалтгаанаар Сангийн яаманд гомдол гаргасан байна.

Сангийн яамны 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 6-1/3416 тоот албан бичгийн дагуу тендерийн баримтыг дахин үнэлж “Рашбай” ХХК-ны ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлж 87.5 сая төгрөгөөр гэрээ байгуулсан.

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр  Сумдын эрүүл мэндийн төвд оношилгооны тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын тендер зарлаж 7 компанид үнийн санал хүргүүлснээс “Гүнтулга” ХХК шалгарч 2021 оны 10 дугаар сарын 07-ний өдөр 192.9 сая төгрөгөөр нийлүүлэх гэрээ байгуулан  2021 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн дотор тоног төхөөрөмжийг хүлээлцэхээр тусгасан байна.

Гэвч тухайн компани нь одоог  хүртэл гэрээний дагуу тоног төхөөрөмжөө нийлүүлээгүй байна. Аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн албан тоотоор тухайн компанид гэрээ цуцлах албан бичиг явуулсан  боловч одоог хүртэл хариу ирээгүй уг ажил хийгдэх үгүй нь тодорхойгүй байна.

Тухайн онд нийт 8,680.9 сая төгрөгийн 230-н бараа,ажил, үйлчилгээ худалдан авах ажил зохион байгуулахаар төлөвлөсөн боловч 1,550.0 сая төгрөгийн 27 бараа,ажил, үйлчилгээ худалдан авах ажлын тендер зарлагдаагүй хасагдсан байна.

### 2.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ихэнх ажлууд хууль, журмын дагуу явагдсан ч зарим хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлууд хууль, журмын дагуу зарцуулагдсан боловч зарим хөрөнгийг зориулалт бусаар зарцуулагдсан байна. Үүнд:

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөс аймаг байгуулагдсаны түүхт 90 жилийн ойд зориулсан бэлэг дурсгалын багцыг 45.0 сая төгрөг төлөвлөж оны эцэст ӨВ. Техник хяналт, барьцаа хөрөнгийн дансанд хийсэн.
2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөнөөс аймаг байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй “Өндөр Гэгээний соёлын өв 2021” урлагийн наадмын зардалд 27.5 сая төгрөг зарцуулсан.
3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөнөөс Хужирт сумын Төрийн албан хаагчийн албан хэрэглээний байр барихад зориулж 150.0 сая төгрөгийн төсөв баталж зураг төсвийн үнэ 19.0 сая төгрөг, гүйцэтгэгч компани руу 131.0 сая төгрөг ондоо багтааж шилжүүлсэн боловч тухайн ажил нь 2022 оны 4  сард очиж үзэхэд эхлээгүй байна. Энэ ажил нь иргэдийн санал аваагүй, ОНХС-ийн журамд нийцээгүй ажил төлөвлөсөн байна.
4. Тарагт сумын Цэцэрлэгийн хүүхдийн тоглоом, тохижилтын 15.0 сая төгрөгийн зардлаас цэцэрлэгийн эрхлэгч өрөөндөө ширээ, сандал, зөөврийн компьютер авсан байна.

## 2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ихэнх төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй хийгдсэн боловч зарим ажлын чанар хангалтгүй байна

### 2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй байна

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1[6], 14 дүгээр зүйлийн 14.2.3[7], 14.3[8] -д төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн удирдлагын талаар заасан.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4-д ОНХС-ийн зорилгыг “Орон

[6] 6.4.Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

[7] 14.2.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

[8] 14.3.Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.

нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ” хэмээн тодорхойлсон байна.

Аймаг, сумдын ОНХС-н хөрөнгөөр 2021 онд хийгдсэн ажлуудын төлөвлөлтийг Удирдлагын мэдээллийн системээс үзэхэд төсөл хэрэгжүүлснээр шийдвэрлэгдэх асуудал буюу төслийн зорилгыг хэт ерөнхий тодорхойлдог, үүнээс үүдэлтэй зорилтот түвшиндээ хэрэгжилт нь хангалттай нийцэхгүй байх асуудал байна. Үүнд:

- Зарим сумдад баригдсан худгуудын хувьд төлөвлөлт хийхдээ зорилтот өрх 10 гэж заасан боловч хариуцуулан хүлээлгэн өгсөн 1 малчин болон ойрын 2-3 өрх малаа усалдаг.
- Тарагт сумын нийтийн худалдааны төв барих ажил нь ажилгүйдлийг бууруулах зорилготой хийгдсэн байхад бодит байдал дээр 1 хүн л алдаг оног ажлын байраар хангагдсан.

Ажлын төлөвлөлтүүд хэт ерөнхий хийгдэх хүрэх түвшнийг нарийн зааж өгдөггүй байна.

Шийдвэрлэх асуудлыг хэрхэн тогтоосныг харуулахад:

*Хүснэгт 9. Аймаг, зарим сумдын ОНХС-ийн төлөвлөлтийн шатанд шийдвэрлэх асуудлыг тусгасан жагсаалт*

| ***Төсөл арга хэмжээний нэр*** | ***Төсөл хэрэгжүүлснээр шийдвэрлэх асуудал*** |
|---|---|
| Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний зардал | Агаарын бохирдол буурч иргэдийн аятай тухтай амьдрах орчин нөхцөл бүрдэнэ. |
| Наадмын талбайн засвар, шинэчлэл хийх | Аймгийн 90 жилийн ойн арга хэмжээний хүрээнд хийхээр төлөвлөсөн |
| Хүнсний ногооны зоорь барих | Зоорьтой болсон байна |
| Спорт залны засвар | Спорт залны засвар |
| Туяа багийн соёлын төвийн засвар тохижилт | Тохижилт хийгдсэн байна |
| Орон нутгийн мэдээллийн хэрэгслийн тоног төхөөрөмж | Орон нутгийн мэдээллийн хэрэгслийн тоног төхөөрөмж |
| Гамшгаас хамгаалах зардал | Сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн багаж, хэрэгсэл |
| Сумын тохижилт үйлчилгээний зардал | Сумын төв тохижилт сайтай болсон байх |
| Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах /засвар/ | Цэцэрлэгт хүрээлэнтэй болно |
| Эрүүл мэндийн төвийн сургалтын байрны дээврийн шинэчлэл,сантехникийн засвар | Дээврийг янзлах |

Дээрх төлөвлөлтийн жишээнээс харахад тухайн аймаг, суманд ямар асуудал шийдвэрлэх шаардлага үүссэн, түүнийг хэрхэн шийдвэрлэх тал дээр төлөвлөлтийн шатанд төдийлөн нарийн сайн төлөвлөлт хийгдээгүй байна.

Гэрээний хугацааг сунгасан, дуусаагүй ажлууд:

1. Аймгийн ОНХС-аас Хархорин сумын гудамж талбайн засвар, шинэчлэл /дутуу, чанар муу/-100.0 сая төгрөг
2. Тарагт сумын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт-15.0 сая төгрөг
3. Баруунбаян-Улаан сумын 2 гүн өрмийн худгийн 30 хувь 13.3 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжүүлсэн тухайн өрөмдсөн газар нь ус гараагүйн улмаас уг худгийн ажил хийгдээгүй байна.
4. Баруунбаян-Улаан сумын ЭМТ-ийн тоног төхөөрөмж-8.5 сая төгрөг
5. Баян-Өндөр сумын Өвсний фондын-60.8 сая төгрөг
6. Баян-Өндөр сумын Хүүхдийн тоглоомын тайлбай барих ажил-24.5 сая төгрөг
7. Баянгол сумын 2 га талбайд ногоон зурвас шинээр байгуулах ажил-25.1 сая төгрөг
8. Бүрд сумын Хүүхдийн тоглоомын талбай-20.0 сая төгрөг
9. Бүрд сумын Сургуулийн биеийн тамирын зааланд бөхийн дэвжээ авах-6.8 сая төгрөг
10. Нарийнтээл сумын Хогийн цэгийг өргөтгөх-16.5 сая төгрөг

11. Нарийнтээл сумын Халуун усны хашаа барих-3.9 сая төгрөг
12. Уянга сумын инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах-6.6 сая төгрөг
13. Уянга сумын Зураг төсөв-3.2 сая төгрөг
14. Хужирт сумын Сумын хүндэтгэлийн хаалганы орчныг тохижуулах 19.7 сая төгрөгийн ажил нь сүүдрэвчийг техникийн тодорхойлолтын дагуу хийгээгүй тул ажлыг хүлээж аваагүй, ажил удааширсан, бүрэн гүйцэтгээгүй байна.
15. Сант сумын Хогийн цэг хашаалах ажил 27.1 сая төгрөгийн ажил дуусаагүй он дамнасан байна.
16. Сант сумын Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах ажил 13.0 сая төгрөгөөр хийгдэх ажил дуусаагүй он дамнасан байна. Цэцэрлэгт хүрээлэн доторх хөшөөг зэсээр бүрэхээр гэрээнд заасан боловч санхүүжилт оройтсон гэсэн шалтгаанаар шавраар бүрэн шавар нурж унан ахин засварлаж зэсээр бүрэхээр болсон.
17. Хархорин сумын Вангийн Овоо, Эрдэнэ толгой, Ганган Орхон багуудад цэвэр усны шугам татах-93.4 сая төгрөг
18. Хархорин сумын Онгоцон ухаа, Нарийн хүр, Шанх багуудын төвийг хашаажуулах ажил-19.3 сая төгрөг
19. Аймгийн Уламжлалтын эмнэлгийн барилга 2020 оны 6 дугаар сарын 05-нд эхэлж тухайн онд 600.0 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч одоо болтол ажил нь дуусаагүй байна.

### 2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ихэнх төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд бодит үр дүнгээ үзүүлсэн боловч зарим ажлууд чанар муутай хийгдсэн байна

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын ихэнх нь үр дүнтэй, олон нийтэд үр өгөөжөө өгсөн ажил болсон байна. Зарим ажлуудаас нь дурдвал:

- Арвайхээр сумын Цэвэр усны эх үүсвэрт давсны уусмалын халдваргүйжүүлэх тоног төхөөрөмжийг 71.2 сая төгрөг.
- Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 220.9 сая төгрөг.
- Есөнзүйл, Хархорин, Арвайхээр сумууд сумын төвийн гүний худгуудыг картаар ажилладаг болгосон.
- Арвайхээр, Хархорин сумдад хийгдсэн гэрэлтүүлэг, цамхагт гэрэл .
- Баянгол сумын Хороололд замын гэрэлтүүлгийн өргөтгөл, өрхийн тариалангийн талбайн трансформаторын засвар ажил.
- Төгрөг сумын Мазар багийн төвд 35 га газар тариалангийн талбайд Газар тариалангийн зориулалттай тоног төхөөрөмжийн ажлын хувьд 54.8 сая төгрөгөөр 90 морины хүчин чадалтай 1 трактор, төмс ухагч 1ш зэрэг тоног төхөөрөмжүүдийг худалдан авч 150 өрх, 3 хоршоо, төсвийн 3 байгууллага төмс, хүнсний ногоо тариалсан байна.

*Зураг 1.Цэвэр усны эх үүсвэрт давсны уусмалын халдваргүйжүүлэх тоног төхөөрөмж*



*Зураг 2. Хархорин суманд хийгдсэн ухаалаг худгийн тоног төхөөрөмж*



*Зураг 3. Төгрөг сумын газар тариалангийн тоног төхөөрөмж*



ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хийгдсэн зарим ажил чанар муутай хийгдсэн байна. Үүнд:

- Тарагт сумын нийтийн худалдааны борлуулалтын цэг нь төслөөс 42.0 сая төгрөг, сумын ОНХС-ийн хөрөнгөнөөс 18.0 сая төгрөгийг зарцуулсан.
- Аймгийн Наадмын талбайн засвар муу хийгдсэн хүндэтгэлийн асрын засвар эхнээсээ будаг нь хуулarsan. /Гуа-Орд компани 154.8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн/
- Зүүнбаян-Улаан сумын “Наадмын талбайн өргөтгөл”-ийн ажил 30.0 сая төгрөгөөр хийгдсэн боловч хийсэн ажил нь техникийн тодорхойлолтоос зөрүүтэй дутуу хийгдсэн.
- Зүүнбаян-Улаан сумын “Явган хүний зам”-ын 8.3 сая төгрөгөөр хийгдсэн ажил нь овон товон ихтэй, хийц муу.
- Бат-Өлзий сумын “Сумын төвийн засмал замын дагуу ногоон байгууламжид хайсан хашаа хийх” ажил 18.0 сая төгрөгөөр хийгдсэн боловч хайсны хувьд бүрэн бэхлээгүй, гагнаас муу, маш их эвдрэлтэй.
- Бат-Өлзий сумын Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс хамтран хийгдсэн мал угаалгын ванн, гүний худгийн ажил 12.0 сая төгрөгөөр хийгдсэн боловч ажил нь дуусаагүй худгийн чайн байрлуулаагүй.
- Өлзийт сумын Цэцэрлэгт хүрээлэнгийн засварын ажлыг 9.8 сая төгрөгөөр хийсэн боловч усан оргилуурын цахилгаан холболт хийгдээгүй.

- Гучин-Ус сумын 10 га газрыг 18.9 сая төгрөгөөр хашаалсан ажлын чанар байдалтай танилцахад хашааны шон суулгахдаа шууд цохиж суулгасан бетондоогүй, шон нь хөдөлгөөнтэй, тор нь чанар муутай хийгдсэн байна.
- Баянгол сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийх Сум тохижилтын ажил /Хог тээвэрлэх, ногоон байгууламжийн арчилгаа, тордлогоо, нийтийн эзэмшлийн байгууламжийн харуул хамгаалалт/ 19.5 сая төгрөгийн ажил чанаргүй, үр өгөөж муутай ажил хийгдсэн.
- Аймгийн ОНХС-аас Хархорин сумын гудамж талбайн засвар, шинэчлэлд 100.0 сая төгрөг төлөвлөж хийсэн ажил нь дутуу, чанар муутай хийгдсэн байна.

*Зураг 4. Баянгол сумын Сум тохижилтын ажил*



*Зураг 5. Гучин-Ус сумын 10 га газар хашаалсан*



*Зураг 6. Бат-Өлзий суманд хийгдсэн хайс*



*Зураг 7. Зүүнбаян-Улаан суманд хийгдсэн явган хүний зам*



Аймгийн 2020 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дараах ажлууд чанаргүй байна. Үүнд:

- Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэг /14 дүгээр цэцэрлэг/ хаалга, цонх, сантехникийн ажил чанар муутай, хана хагарсан.
- Нарийнтээл сумын СӨББ-ийн өргөтгөлийн барилгын ажил одоогоор нэг талын хана халцарсан.

Цар тахлын улмаас зарим ажил гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүйгээс гэрээний хугацаанд өөрчлөлт оруулан ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

*Хүснэгт 10. Гэрээний хугацаа хойшилсон ажлуудын жагсаалт*

| № | Ажлын нэр | Гүйцэтгэгч | Гэрээний хугацаа | Хойшлогдон хийгдсэн хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Аймгаас Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эмчилгээний тоног төхөөрөмж нийлүүлэх-220.9 сая | “Ай мед технложис” ХХК | 2021.12.11-ний дотор | 2022.04.05 дотор |
| 2 | Аймгаас ногоон байгууламжийн хайс засварлах шинээр солих, I LOVE | “Хөшиг-Уул” ХХК | 2021.08.19-ны дотор | 2021.11.20 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ARVAIKHEER үсгэн хэлбэрт биет бэлгэ тэмдэг хийх ажил-79.6 сая | | | |
| 3 | Аймгаас Ногоон байгууламж хайс хашлага будаж шинэчлэх ажил-71.5 сая | “Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ | 2021.08.19-ны дотор | 2021.11.16 |
| 4 | Арвайхээр сумын соёл амралтын хүрээлэнгийн гэрэлтүүлэг хүндэтгэлийн хаалганы засварын ажил-57.4 сая | “Арвайхээр хотын нийтийн гэрэлтүүлэг” ОНӨААТҮГ | 2021.08.19 дотор | 2021.11.11 |
| 5 | Арвайхээр сумын Нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлгийн засвар, шинэчлэлийн ажил-69.9 сая | Арвайхээр хотын нийтийн гэрэлтүүлэг” ОНӨААТҮГ | 2021.08.19 дотор | 2021.09.19 |
| 6 | Өлзийт сумын Гэр хорооллын гудамжны засварын ажил-9.8 сая | Өлзийт сумын Иргэн Б.Батжаргал | 2021.07.05-ны дотор | 2021.11.02 |
| 7 | Өлзийт сумын Соёлын төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх-9.0 сая | Өлзийт сумын Иргэн Ш.Эрдэнэбаяр | 2021.08.01 дотор | 2021.10.29 |
| 8 | Өлзийт сумын Наадмын талбайн тохижилтын ажил-6.79 сая | Борхын цагаан овоо ХХК | 2021.07.10 | 2021.09.01 |
| 9 | Сант сумын Булгийн эх хашиж хамгаалах ажил-3.0 сая | Сант сумын Иргэн С.Ганшагай | 2021.10.30 дотор | 2021.12.20 |

ОНХС-ийн хөрөнгөөр 2021 оны зарим ажлууд гэрээний хугацаа сунгаж, он дамжсан байна. Үүнд:

1. Аймгийн ОНХС-аас Хархорин сумын гудамж талбайн засвар, шинэчлэлд 100.0 сая төгрөг төлөвлөж хийсэн ажил нь дутуу, чанар муутай хийгдэж байна.
2. Тарагт сумын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт 15.0 сая төгрөг
3. Баруунбаян-Улаан сумын 2 гүн өрмийн худгийн 30 хувь 13.3 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжүүлсэн тухайн өрөмдсөн газар нь ус гараагүйн улмаас уг худгийн ажил хийгдээгүй байна.
4. Баруунбаян-Улаан сумын ЭМТ-ийн тоног төхөөрөмж 8.5 сая төгрөгөөр нийлүүлэх ажил
5. Баян-Өндөр сумын Өвсний фондын 60.8 сая төгрөгийн ажил.
6. Баян-Өндөр сумын Хүүхдийн тоглоомын тайлбай барих ажил 24.5 сая төгрөгийн ажил.
7. Баянгол сумын 2 га талбайд ногоон зурвас шинээр байгуулах ажил 25.1 сая төгрөгөөр хийгдэх ажил.
8. Бүрд сумын Хүүхдийн тоглоомын талбай 20.0 сая төгрөгийн ажил.
9. Бүрд сумын Сургуулийн биеийн тамирын зааланд бөхийн дэвжээ авах 6.8 сая төгрөгийн гэрээ байгуулж 3.4 сая төгрөг нь ОНХС-аас гаргахаар гэрээнд заасан
10. Нарийнтээл сумын Хогийн цэгийг өргөтгөх 16.5 сая төгрөгийн ажил.
11. Нарийнтээл сумын Халуун усны хашаа барих 3.9 сая төгрөгийн ажлууд тус тус дуусаагүй байна.
12. Уянга сумын инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах 6.6 сая төгрөгийн санхүүжилттэй ажил хийгдээгүй.
13. Уянга сумын Зураг төсөв хийх 3.2 сая төгрөгийн ажил хийгдээгүй.
14. Хужирт сумын Сумын хүндэтгэлийн хаалганы орчныг тохижуулах 19.7 сая төгрөгийн ажил нь сүүдрэвчийг техникийн тодорхойлолтын дагуу хийгээгүй тул ажлыг хүлээж аваагүй, ажил удааширсан, бүрэн гүйцэтгээгүй байна.
15. Сант сумын Хогийн цэг хашаалах ажил 27.1 сая төгрөгийн ажил дуусаагүй он дамнасан байна.

16. Сант сумын Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах ажил 13.0 сая төгрөгөөр хийгдэх ажил дуусаагүй он дамнасан байна. Цэцэрлэгт хүрээлэн доторх хөшөөг зэсээр бүрэхээр гэрээнд заасан боловч санхүүжилт оройтсон гэсэн шалтгаанаар шавраар бүрэн шавар нурж унан ахин засварлаж зэсээр бүрэхээр болсон.
17. Хархорин сумын Вангийн Овоо, Эрдэнэ толгой, Ганган Орхон багуудад 93.4 сая төгрөгөөр цэвэр усны шугам татах ажлууд дуусаагүй байна.
18. Хархорин сумын Онгоцон ухаа, Нарийн хүр, Шанх багуудын төвийг хашаажуулах ажлыг 19.3 сая төгрөгийн ажил дуусаагүй байна.

## 2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна

### 2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэж заасны дагуу ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон эд хөрөнгө нь орон нутгийн төсөв, санхүүгийн дэмжлэг, хуульд заасан бусад эх үүсвэрээр бий болсон эд хөрөнгийн ангилалд хамаарна.

Аймаг, сумын ИТХ-аас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3[9]-д заасны дагуу орон нутгийн өмчийг эзэмшүүлж, ашиглуулах шийдвэр гаргана.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ашиглалт сайтай ажлуудаас дурдвал:

- Арвайхээр сумын ОНХС-ийн хөрөнгөөр Худаг, ус түгээх байруудыг засварлах ажлыг 173.8 сая төгрөгөөр ундны усны 14 худагт цахимжуулах ажил хийгдсэн, 1 худаг шинээр бий болгож зөөврийн усан сан бий болгосон байна. Энэ худгуудын ашиглалтыг Онги-Ус суваг, Арвайхээр сумын хот тохижилтын газраас камераар харж хяналтыг тавьж ажиллаж байна.
- Арвайхээр суманд цэцэрлэгжүүлэлтийн ажил 25.0 сая төгрөгөөр хийгдэж гудамж талбайг моджуулах ажлыг нэмэгдүүлсэн.
- Аймгийн эрүүл мэндийн төвийн дэргэд 176.0 сая төгрөгөөр зориулалтын эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахтай болгосноор вакцин хадгалалтын нөхцөл сайжирсан.
- Есөнзүйл суманд хуучин сургуулийн ашиглалтгүй болсон спорт заланд 39.4 сая төгрөгөөр засвар хийж хүүхэд залуучуудын чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх боломж бүрдсэн байна.
- Хужирт сумын ЕБС-д 6.9 сая төгрөгийн урлаг заалны хөгжим, аппарат, сандал шинэчлэх ажил хийгдсэн. Тус тоног төхөөрөмж нь байнгын ашиглалт сайтай, сурагчдын урлаг, спортын үйл ажиллагаа явуулах нөхцөлийг улам бүр сайжруулжээ.
- Сант суманд Халуун ус шинээр барих ажлыг 79.9 сая төгрөгөөр хийгдсэн. Сумын иргэдийн хэрэгцээ, шаардлага бүрэн хангагдсан, ашиглалт сайн байна.

Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.12 дахь заалтад “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасан байдаг. Энэ дагуу тухайн хөрөнгийн ашиглалттай холбоотой жил

[9] 3. Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

бүрийн урсгал зардал, хөрөнгөд хийх засвар үйлчилгээний зардлыг төсөвт байгууллагууд өөрийн хөрөнгийн бүртгэлд тусган, ашиглалтыг хариуцан ажиллаж байна. Сумдын хувьд ОНХС-н хөрөнгөөр бий болсон худаг, халуун ус зэргийг иргэдэд гэрээгээр хариуцуулан ажиллуулж байна.

ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг эзэмшиж, ашиглах үүрэг хүлээсэн тухайн байгууллага нь үндсэн хөрөнгийн ашиглалт талын хариуцлагыг сайжруулж, жилийн эцсийн тооллогын үр дүнгээр баталгаажуулан, өмч хамгааллын гэрээ байгуулж дүгнэн ажиллаж байх шаардлагатай байна.

Аймаг, сумын ОНХС-аас 2021 онд хийгдсэн ажлуудаас дараах хөрөнгүүд ашиглалт муу байна. Үүнд:

- Тарагт сумын нийтийн худалдааны борлуулалтын цэг нь 60.0 сая төгрөгөөр тендер зарлаж төслөөс 42.0 сая төгрөг, сумын ОНХС-ийн хөрөнгөнөөс 18.0 сая төгрөгийг зарцуулсан, хөрөнгийн ашиглалт хангалтгүй 1 хүн л цайны газар ажиллуулж байна.
- Тарагт сумын нийтийн бие засах газрыг худалдааны төв дотор 20.0 сая төгрөгөөр хийсэн боловч ашиглалтгүй байна.
- Арвайхээр сумын ундны усны 3-н худагт 2.5 сая төгрөгөөр халуун усны төхөөрөмж/ цахилгаан бойлуур/ тавьсан боловч ашиглалт байхгүй, тогийн мөнгө их гардаг байна.
- Аймгийн сурын талбайн тохижилтын ажил 65.0 сая төгрөгөөр хийсэн боловч ашиглалтгүйгээс гадаа хураалттай байна. /Арвайхээр, хот тохижилтын хөрөнгийн хадгалалт хамгаалалт хангалтгүй байна/
- Агаарын бохирдлыг бууруулах ажил 300.0 сая төгрөгөөр хийгдсэн боловч тодорхой үр дүн гараагүй байна.

Өмнөх оны ажлуудаас Уянга суманд 2019 оны ОНХС-с хийгдсэн 42.0 сая төгрөгийн өртөг бүхий камержуулалтын ажил 2022 оны байдлаар ашиглалтгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын ашиглалт тал дээр хөрөнгө хариуцсан байгууллагын удирдлага, иргэдийн хяналтыг сайжруулах, аймаг, сумдын Засаг дарга нар хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

### 2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй, аймаг, сумдын ИТХ, иргэдийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна

ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалтын талаар Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.12[10]-д заасан.

ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хийгдсэн ажлуудаас түүвэрлэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар Зүүнбаян-Улаан, Төгрөг, Нарийнтээл, Гучин-Ус, Баян-Өндөр, Өлзийт, Хужирт, Сант, Баянгол зэрэг сумдаас судалгаа авсан. Тус судалгаагаар хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын талаар одоогоор хүндрэлтэй асуудал үүсээгүй, ашиглалт хэвийн байна.

Харин хөрөнгийн хадгалалт, хамгаалалттай холбоотой дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- Гучин-Ус суманд 2020 оны сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн сумын төвийн ундны усны гүний худгийг автомат системтэй болгох ажил 24.0 сая төгрөгөөр

[10] ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

хийгдсэн боловч гадна камер эвдэрсэн, өвлийн улиралд карт уншигч доголдолтой ажилладаг.

- Баянгол суманд 2020 оны сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн сумын тохижилт үйлчилгээний ажил 9.0 сая төгрөгөөр хийгдсэн боловч хайсан хашааг иргэд гэмтээж, эвдэлсэн.
- Баянгол сумын цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн төмөр хайс хийх ажлыг 12.6 сая төгрөгөөр хийж сагс, гар бөмбөгийн хосолсон талбайг шинээр хийсэн боловч талбайн үзэгчдийн сандал, хогийн савны эвдрэл гэмтлийг засварлах зардал байхгүй байна.
- Уянга суманд 2019 оны ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 86.8 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгт хүрээлэн ашиглалтын зардал шийдэгдээгүй, харуул хамгаалалтгүй, камержуулалт хангалтгүй байсны улмаас ихээхэн хэмжээний эвдрэл гэмтэл үүссэн байна.

Сумуудын 2021 оны ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг үзэхэд хайсан хашаа, тоглоомын талбайн эвдрэл, гэмтлүүд үүсэж эхэлсэн байна.

*Зураг 8. Бат-Өлзий сумын хайс*



*Зураг 9. Хархорин сумын тоглоомын талбай*



Хүүхдийн тоглоомын талбай, хайсан хашаа зэрэг хөрөнгөнүүд иргэдийн ашиглалтын байдлаас хамааран эвдрэл гэмтэл үүсдэг, тэдгээрийн засварлах урсгал зардлын төсөв байдаггүй нь дээрх судалгааны үр дүн, жил жилийн ОНХС-гийн аудитаар нийтлэг ажиглагддаг асуудал юм. ОНХС-ийн төлөвлөлт хийгдэх үед хөрөнгийн ашиглалтын урсгал зардлуудыг ихэвчлэн төсвөөс шийдвэрлэхээр хийгдсэн боловч төсөвт урсгал зардлын мөнгө байхгүй байна.

“Тогтвортой амьжиргаа-3” төслийн Хөрөнгийн удирдлага гарын авлагад өмчийн ашиглалтын урсгал зардлыг дараах байдлаар иргэдийн оролцоотой шийдвэрлэх боломжтой гэсэн байна. Үүнд:

- ЭВ САНААНЫ НЭГДЛИЙН ЗАРЧИМ Нийтийн эрх ашгийн үүднээс нийт иргэд (зорилтот бүлэг) ашиглалтын урсгал зардлыг тэнцүү хувааж төлөх
- ХАГАС ХАРИУЦЛАГЫН ЗАРЧИМ Өмчийн үр шимийг хүртсэн иргэн хагас зардлыг, хагас зардлыг "эв санааны нэгдлийн зарчим"-аар шийдвэрлэх
- БҮРЭН ХАРИУЦЛАГЫН ЗАРЧИМ Өмчийн үр шимийг хүртсэн иргэн ашиглалтын урсгал зардлыг бүрэн хариуцах зарчим

Иргэд тав тухтай орчинд амьдрах хүсэл, шаардлага их байдаг ч төсвийн хөрөнгөөр бий болсон их, баг хэмжээний нийтийн хэрэгцээний хөрөнгийг ашиглахдаа төдийлөн хариуцлагатай биш байна. Тиймээс хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт дээр иргэдийн хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн “Орон нутгийн өмчийн талаарх иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх” 77.2.1-д “орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;” гэж заасан байна. Иймд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар аймаг, сумдын ИТХ-ын хяналтаа тавих шаардлага байна.

# 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ БҮРЭН ХЯНАЛТ ТАВЬЖ, ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА

## 3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хийсэн хяналт хангалтгүй байна

### 3.1.1. Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд хийсэн хяналт хангалтгүй байна

Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.4-д заасны дагуу ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэлд шат шатны ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагаас хяналт тавих үүрэгтэй.

Аймгийн ИТХ-аас 2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын үр дүн, үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажил хийгдээгүй байна.

Харин сумдын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр гэрээ байгуулсан 186 төсөл арга хэмжээнээс 117 төсөл, арга хэмжээнд хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтуудын ажилд аймаг, сумын ИТХ, Засаг даргын хяналт сул байгаа нь төсөл, арга хэмжээ дутуу буюу чанаргүй хийгдэх, хугацаандаа хийгдэхгүй байх эрсдэлтэй байна.

*Хүснэгт 11. Сумдын ИТХ-ын хяналтын хорооноос ирүүлсэн хяналтын тайлангийн хэрэгжилт*

| № | Сумын нэр | Гэрээ байгуулсан ХО, төсөл, арга хэмжээ | | Сумын ИТХ-ын хяналтын хорооны тайлан | |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Мөнгөн дүн / сая.төг/ | Хяналт хийсэн төсөл, арга хэмжээний тоо | Хяналт хийгээгүй төсөл, арга хэмжээний тоо |
| 1 | Баян-Өндөр | 12 | 247.1 | 5 | 7 |
| 2 | Бүрд | 6 | 113.0 | 4 | 2 |
| 3 | Бат-Өлзий | 7 | 366.6 | 4 | 3 |
| 4 | Баруунбаян-Улаан | 8 | 142.2 | 3 | 5 |
| 5 | Баянгол | 5 | 110.1 | 5 | 0 |
| 6 | Гучин-Ус | 10 | 130.4 | 5 | 5 |
| 7 | Есөнзүйл | 10 | 116.1 | 2 | 8 |
| 8 | Өлзийт | 8 | 67.9 | 4 | 4 |
| 9 | Зүүнбаян-Улаан | 9 | 87.9 | 1 | 8 |
| 10 | Хайрхандулаан | 10 | 124.9 | 2 | 8 |
| 11 | Нарийнтээл | 9 | 146.5 | 3 | 6 |
| 12 | Сант | 6 | 132.4 | 5 | 1 |
| 13 | Тарагт | 10 | 131.7 | 3 | 7 |
| 14 | Төгрөг | 4 | 78.1 | 1 | 3 |
| 15 | Уянга | 10 | 186.1 | 0 | 10 |
| 16 | Богд | 12 | 341.7 | 2 | 10 |
| 17 | Хужирт | 8 | 191.5 | 1 | 7 |
| 18 | Хархорин | 37 | 490.6 | 17 | 20 |
| 19 | Арвайхээр | 4 | 297.5 | 2 | 2 |
| | Нийт дүн | 186 | 3502.2 | 69 | 117 |

Баян-Өндөр, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Хайрхандулаан, Тарагт, Төгрөг, Уянга, Богд, Арвайхээр сумуудын ИТХ-аас тавьсан хяналт хангалтгүй байна.

### 3.1.2 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийг төлөөлж аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, ГХБХБГ нь захиалагчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээ байгуулан хяналтыг хэрэгжүүлж, сумдад захиалагчийн хяналтыг ЗДТГ-ын ажилтнууд гүйцэтгэж байна.

Сумдын ЗДТГ-ын ажилтнууд захиалагчийн хяналт тавихад нарийн мэргэжлийн талаасаа гүйцэтгэгч байгууллагад шаардлага бүрэн тавьж чаддаггүй, зарим ажил нь захиалагчийн хяналтын зардал байхгүй зэргээс шалтгаалж төсөл, арга хэмжээ үр дүнгүй, хугацаандаа хэрэгждэггүй зөрчлүүд гарч байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн захиалагчийн хяналтын тайлангаас харахад нэг төсөл арга хэмжээнд 2-5 удаа хяналт хийн 3-36 төрлийн үүрэг даалгавар, зөвлөмж өгч ажилласан боловч үе шатны хяналтаар илэрсэн зөрчлийг дурдан гүйцэтгэгч байгууллагаар зөвшөөрүүлж баталгаажуулаагүй, илэрсэн зөрчилд үүрэг даалгавар өгч биелэлтийг дүгнэсэн талаар тайлагнаагүй байна.

***График 1. ОНХС-ийн ажилд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас хийсэн захиалагчийн хяналт***



***График 2. ОНХС-ийн ажилд ХБТХОХ-ийн хийсэн захиалагчийн хяналт***




Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хийгдсэн төсөл арга хэмжээний баримт бичгээс үзэхэд захиалагчийн хяналтаар илэрсэн зөрчил, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар дурдаагүй, үнэлж, дүгнэж тэмдэглэл хөтөлж хэвшээгүй байна.Тухайлбал:

Аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь дараах ажлуудын улаан, цагаан дэвтэр дээр тэмдэглэл үйлдээгүй байна. Үүнд:

- Арвайхээр сумын 212, 455 дугаар байруудын дээвэр, зарим хуучин орон сууцуудын ус буулгагч болон гадна дулааны худагт Ф50, 100мм хаалт солих, засварлах
- Арвайхээр сумын 300 дугаар байр /12 айлын орон сууц/-ны дээврийн засвар
- Арвайхээр сумын 153 дугаар байр/ хангамжийн 24 айлын орон сууцны дээврийн засвар/
- Арвайхээр сумын 8 дугаар байр /ТИС-ийн 8 орон сууц/-ны дээврийн засвар
- Арвайхээр сумын 14 дугаар байр /ТИС-ийн 14 орон сууц/-ны дээврийн засвар
- Арвайхээр сумын 108 дугаар байр /60 айлын орон сууц/-ны дээврийн засвар
- Арвайхээр сумын 203 дугаар байр /Шинэ 48 айлын орон сууц/-ны дээврийн засвар
- Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт
- Явган зам, замын хашлага, хурд сааруулагчийн засвар

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь Наадмын талбайн засвар шинэчлэл 6, 7 багц ажлын улаан, цагаан дэвтэр дээр тэмдэглэл үйлдээгүй байна.

Харин доорх ажлуудад хяналт тавьж ирсэн байна. Үүнд:

1. Нийгмийн эрүүл мэндийн төвийн агуулах барих ажилд ГХБХБГ-аас 1 удаа хяналт хийж 7 үүрэг даалгавар өгсөн.

2. Нисэхийн зүүн талын 1 км урттай авто замын шинэчлэлийн ажилд МХГ-аас 5 удаа хяналт хийж 12 үүрэг даалгавар, захиалагч байгууллагаас 4 удаа хяналт хийж 14 үүрэг даалгавар өгсөн.
3. Дэлгэрэх голын голдирлын тохижилтын ажилд ГХБХБГ-аас 2 удаа хяналт хийж 21 үүрэг даалгавар өгсөн.
4. Ногоон байгууламжийн хайс засварлах, шинээр солих, I LOVE ARVGAIHEER үсгэн хэлбэрт биет бэлгэ тэмдэг хийх ажилд ХБТХОХ-ээс 1 удаа хяналт хийж 3 үүрэг даалгавар өгсөн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад ГХБХБГ-тай 21.1 сая төгрөгийн захиалагчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээ хийсэн боловч зардлыг аймгийн техник хяналт барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Иймд барилга байгууламж, их засварын ажлын чанар, аюулгүй байдлыг хангах, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс ОНХС-ийн үйл ажиллагааны журмын дагуу сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд техник хяналтын зардлыг гэрээнд заасны дагуу зардлыг бүрэн олгож байх шаардлагатай байна.

Харин аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 01 –ны өдрийн А/534 тоот захирамжаар 23.0 сая төгрөгийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт захиалагчийн зүгээс техник хяналтын зардалд зарцуулахаар шилжүүлсэн боловч ямар хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжсэн төсөл арга хэмжээний техник хяналтын зардал болох нь тодорхойгүй байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ГХБХБГ-т захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжүүд дутагдалтай байдаг байна.

### 3.1.3. Төрийн аудитын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил бүрэн биелэгдэж, дотоод аудит, хяналт шалгалт 2021 онд хийгдээгүй байна

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн үйл ажиллагааны журам”-ын 9.4-т заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Тогтвортой амьжиргаа -3 төслөөс жилийн гүйцэтгэлийн үнэлгээг хөндлөнгийн 3 компаниар гэрээ байгуулж аудит хийлгэдэг бөгөөд тус үнэлгээг 6 бүлэг 34 шалгуураар 2021 оны 8 сард хийж дүгнэсэн байна.

Өвөрхангай аймгийн сумдын 2019-2021 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээний дүнг харьцуулахад 8 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

*Хүснэгт 12. Өвөрхангай аймгийн сумдын 2019- 2021 оны ЖГҮ-ний үр дүн ба урамшууллын хэмжээ /сая.төг/*

| Сумын нэр | 2019 он | | 2020 он | | 2021 он | | Өсөлт % |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ЖГҮ оноо | Урамшуулал | ЖГҮ оноо | Урамшуулал | ЖГҮ оноо | Урамшуулал | |
| Баян-Өндөр | 64% | 23.9 | 65% | 28.1 | 90% | 47.2 | 26% |
| Бүрд | 66% | 19.4 | 65% | 22.8 | 69% | 19.2 | 3% |
| Бат-Өлзий | 83% | 37.1 | 90% | 54.3 | 94% | 73.1 | 11% |
| Баруунбаян-Улаан | 79% | 24.3 | 75% | 28.4 | 91% | 47.8 | 12% |
| Баянгол | 79% | 22.2 | 73% | 26.0 | 89% | 35.0 | 10% |
| Гучин-Ус | 85% | 20.5 | 84% | 30.1 | 94% | 40.4 | 9% |
| Есөнзүйл | 80% | 17.2 | 85% | 25.1 | 83% | 27.1 | 3% |
| Өлзийт | 83% | 13.1 | 64% | 15.4 | 76% | 15.5 | -7% |
| Зүүнбаян-Улаан | 89% | 18.1 | 84% | 26.4 | 93% | 35.6 | 4% |
| Хайрхандулаан | 83% | 21.8 | 91% | 32.0 | 96% | 43.1 | 13% |
| Нарийнтээл | 83% | 22.7 | 83% | 33.3 | 87% | 35.9 | 4% |
| Сант | 78% | 20.0 | 76% | 23.5 | 87% | 31.5 | 9% |
| Тарагт | 91% | 17.2 | 81% | 25.2 | 93% | 33.9 | 2% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Төгрөг | 84% | 24.1 | 73% | 28.2 | 89% | 37.9 | 5% |
| Уянга | 73% | 36.4 | 40% | 0 | 66% | 35.8 | -7% |
| Богд | 81% | 56.7 | 92% | 83.2 | 95% | 111.9 | 14% |
| Хужирт | 77% | 27.3 | 84% | 40.0 | 87% | 43.1 | 10% |
| Хархорин | 73% | 60.4 | 82% | 88.4 | 77% | 71.4 | 4% |
| Арвайхээр | 79% | 59.5 | 76% | 69.7 | 97% | 117.2 | 18% |
| **Нийт дүн** | **79%** | **542.2** | **77%** | **680.2** | **87%** | **903.0** | **8%** |

Сумдын жилийн гүйцэтгэлийн үнэлгээг бүлгээр авч үзвэл ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг иргэд, олон нийтийн оролцоог хангаж ажилласан байдлыг хамгийн өндрөөр үнэлсэн байна. Харин төсөвтэй холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлсэн байдлыг хамгийн багаар үнэлсэн байна. Тус үнэлгээг онооны системээр үнэлдэг бөгөөд хамгийн өндөр оноо авснаар ОНХС-ийн жилийн батлагдсан төсвийн 50 хувийг урамшуулал хэлбэрээр олгодог байна.

*Хүснэгт 13. Өвөрхангай аймгийн 2021 оны сумдын ЖГҮ-ний үр дүн, бүлгээр*

| Сумын нэр | Олон нийтийн оролцоо | Төлөвлөлт | Ил тод байдал | Гүйцэтгэл | ХШҮ | Өмчийн удирдлага | Сумын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Баян-Өндөр | 100% | 97% | 78% | 84% | 86% | 100% | 90% |
| Бүрд | 94% | 91% | 51% | 39% | 85% | 52% | 69% |
| Бат-Өлзий | 100% | 96% | 78% | 100% | 100% | 89% | 94% |
| Баруунбаян-Улаан | 100% | 96% | 89% | 72% | 100% | 100% | 91% |
| Баянгол | 100% | 93% | 84% | 91% | 69% | 87% | 89% |
| Гучин-Ус | 98% | 99% | 84% | 88% | 100% | 100% | 94% |
| Есөнзүйл | 100% | 93% | 84% | 80% | 57% | 60% | 83% |
| Өлзийт | 100% | 89% | 70% | 35% | 100% | 71% | 76% |
| Зүүнбаян-Улаан | 100% | 100% | 78% | 87% | 86% | 100% | 93% |
| Хайрхандулаан | 98% | 99% | 89% | 100% | 88% | 100% | 96% |
| Нарийнтээл | 100% | 93% | 68% | 91% | 84% | 81% | 87% |
| Сант | 100% | 83% | 79% | 97% | 75% | 85% | 87% |
| Тарагт | 100% | 100% | 78% | 100% | 65% | 100% | 93% |
| Төгрөг | 99% | 97% | 78% | 100% | 65% | 68% | 89% |
| Уянга | 79% | 72% | 54% | 72% | 59% | 45% | 66% |
| Богд | 100% | 94% | 89% | 96% | 100% | 100% | 95% |
| Хужирт | 95% | 100% | 62% | 84% | 100% | 70% | 87% |
| Хархорин | 91% | 82% | 84% | 76% | 27% | 75% | 77% |
| Арвайхээр | 100% | 98% | 89% | 96% | 100% | 100% | 97% |
| **Дундаж үнэлгээ** | **98%** | **93%** | **77%** | **84%** | **81%** | **83%** | **87%** |

Өвөрхангай аймгийн 2019 оны ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар 1071.2 сая төгрөгийн албан шаардлага, 7 зөвлөмж өгснөөс биелэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

## 3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу хүргүүлсэн боловч тайлагналт хангалтгүй байна

### 3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг тайлагнасан боловч хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна

ОНХС-ийн үйл ажиллагааны журамд ОНХС-аас хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний талаар тайлагнахдаа журмын 9.4, 9.5-д заасан этгээдийн хийсэн ажлын тайлан, тэмдэглэл, гаргасан дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлж байхаар заасан байна.

Тус журмын 9.5-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Журам шинэчлэн батлах тухай" 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар

батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ” гэж заасан боловч аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс ОНХС-ийн 2021 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдээгүй байна.

ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9 дүгээр зүйлийн 9.9.-т “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС–ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана” гэж заасны дагуу ОНХС-ийн гүйцэтгэл, зарцуулалтын тайланг хавсралт 21 хуудас бүхий аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 2 дугаар сарын 16-ны 3/84 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр 226 төсөл, арга хэмжээнд 8,342.8 сая төгрөг зарцуулсан тайлан гаргасан байна.

Иймд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг сайжруулах үүднээс хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлан дүгнэлтийг аймаг, сумдын ИТХ-аар хэлэлцүүлж байх шаардлагатай байна.

### 3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэж тайлагнасан байна.

Аймаг, сумын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэх, ашиглагдах хөрөнгийн шинж байдал, зориулалтыг харгалзан орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн өмчлөлд шилжүүлж ашиглуулах шийдвэр гаргаж ажилласан байна.

ОНХС-ийн хөрөнгийг тайлагнахдаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу зарим сумууд ОНХС-ийн хөрөнгөөс олгосон урьдчилж төлсөн төлбөрийг тайлагнаагүй байна.

*Хүснэгт 14. Санхүүгийн тайланд бүртгэзгүй урьдчилж төлсөн зардлын дүн*

| № | Сумын нэр | Төсөл, арга хэмжээний тоо | Урьдчилж төлсөн зардал |
|---|---|---|---|
| 1 | **Бат-Өлзий ОНХС** | 1 | 12.0 |
| 2 | **Бүрд сум ОНХС** | 2 | 18.4 |
| 3 | **Баянгол сум ОНХС** | 2 | 35.7 |
| 4 | **Нарийнтээл ОНХС** | 2 | 11.1 |
| 5 | **Сант ОНХС** | 2 | 24.0 |
| 6 | **Тарагт ОНХС** | 2 | 24.5 |
| 7 | **Хужирт ОНХС** | 2 | 61.3 |
| 8 | **Хархорин ОНХС** | 8 | 104.6 |
| 9 | **Гучин-Ус ОНХС** | 1 | 4.0 |
| | **Нийт дүн** | 24 | 295.6 |

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөс олгосон урьдчилж төлсөн зардлуудыг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тайланд тусгаж НББ-ийн тухай хууль, бусад заавар журмын хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

### 3.2.3. Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэдэд ил тод нээлттэй мэдээлэх ажил хангалтгүй байна.

ОНХС-ийн УМС нь орон нутгийн хүрээнд санхүүжүүлэх болон цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын талаар мэдээллийн санг бүрдүүлэх зорилготой бөгөөд ОНХС-тай холбоотой төсөл, арга хэмжээг хэрэгжиж буй эсэх асуудалд

хяналт тавих боломж бий болж цаашид системээр дамжуулан мэдээллийн сан бүрдүүлж, хуваарилалт, төлөвлөлт хийх, төслийн санхүүжилт, гүйцэтгэлийг удирдах, тайлагнах, үнэлгээ хийхэд ашиглахаар 2020 онд нэвтэрсэн программ юм.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 10 дугаар зүйлийн 10.2-т " ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, тайлагналт, бүртгэлд удирдлагын мэдээллийн систем ашиглах ба орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, санхүүжилтийн хуваарь, төлбөрийг бүртгэнэ" гэж заасан байна.

Өвөрхангай аймгийн ОНХС-ийн УМС-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийг аудитын явцад тулган шалгахад төлөвлөлт, зарцуулалтын талаарх мэдээллүүд зөрүүтэй байна.

*Хүснэгт 15. Удирдлагын мэдээллийн системд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтийг оруулсан байдал /сая. төг/*

| № | Сумын нэр | 2021 онд ИТХ-аар батлагдсан төсөл, арга хэмжээ | | 2021 онд УМС-д бүртгэгдсэн төсөл, арга хэмжээ | | Зөрчлийн дүн | |
|---|---|---|---|---|---|---|---|
